

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

(Хамрах хугацаа: 2022.01.06-2022.12.26)

2022.12.26.

Улаанбаатар хот

Нэг. Зохион байгуулалтын хүрээнд:

Салбар зөвлөлийн хуралдааныг 2022 онд 4 удаа зохион байгуулж, дараах 8 асуудлыг хэлэлцэж, холбогдох тогтоол, дүгнэлт, чиглэлийг баталлаа. Үүнд:

- 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01 дүгээр хуралдаанаар: салбар зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, 2022 оны төлөвлөгөөний төслийг хэлэлцэн батлах;
- Мөн хуралдаанаар: Гадаадын иргэн, харьяатын газрын “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх сургалтын болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2022 оны төлөвлөгөөний төслийг хэлэлцэх;
- 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар хуралдаанаар: төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт зохион байгуулах шалгалтын комисс байгуулах, төрийн захиргааны албан тушаалд төрийн байгууллагаас шилжин томилох албан хаагчийн талаар хэлэлцэж, дүгнэлт гаргах эсэх тухай;
- 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 03 дугаар хуралдаанаар салбар зөвлөлөөс 2022 оны эхний хагас жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны мэдээлэл танилцуулах;
- Мөн хуралдаанаар салбар зөвлөлийн гишүүд, сонгон шалгаруулалтын комисст ажилласан төрийн жинхэнэ албан хаагчид мөнгөн урамшуулал олгох эсэх асуудлыг хэлэлцэх;
- 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 04 дүгээр хуралдаанаар төрийн тусгай болон үйлчилгээний удирдах албан тушаалын ангилал, зэрэглэлтэй төрийн захиргааны албан тушаалыг адилтган авч үзэх жагсаалтад тусгах санал танилцуулах.

Салбар зөвлөл нь жилийн дүнгээр 24 тогтоол баталж, хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд:

- Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргүүлэх тухай 01, 14, 24 дүгээр тогтоол;
- Салбар зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай 03 дугаар тогтоол;
- Удирдах албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын комисс байгуулах тухай 02, 20 дугаар тогтоол;
- Салбар зөвлөлийн гишүүдэд цалингийн урамшуулал олгох тухай 04, 19 дүгээр тогтоол;

➤ Нэр дэвшүүлэх тухай 05, 06, 07, 08, 09, 10, 11, 12, 15, 16, 17, 18, 21, 22, 23 дугаар тогтоол;

➤ Гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх шалгалтын комисс байгуулах тухай 13 дугаар тогтоол.

Салбар зөвлөлд 2022 онд Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн 3 тогтоол, 1 зөвлөмж, 2 хуралдааны тэмдэглэл, 10 албан бичиг, явуулсан албан бичгийн тоо 9, үүнээс хариутай 2 албан бичгийг заасан хугацаанд бүрэн хүргүүлэв.

Салбар зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг тооцоход жилийн дүнгээр 96.2 хувийн биелэлттэй.

Тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөлийн холбогдох нэгжид дараах мэдээ, судалгааг хүргүүлсэн. Үүнд:

Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн "Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 411 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах тухай" 06-05/226 албан бичгийн 1, 2 дугаар хавсралт тогтоолын хэрэгжилтийн мэдээг нэгтгэн байгууллагын даргын 01/280 албан бичгээр албан бичгээр;

Төрийн албаны чадавхыг бэхжүүлэх чиглэлээр 2022 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг нэгтгэн байгууллагын даргын 11 дүгээр сарын 07-ны өдрийн 01/1937 албан бичгээр;

Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайланг нэгтгэж, байгууллагын даргын 06 дугаар сарын 22-ны өдрийн 01/1156 албан бичгээр;

Төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан тушаалын сул орон тооны сонгон шалгаруулалт зохион байгуулах захиалгыг салбар зөвлөлийн 8 удаагийн албан бичгээр;

Салбар зөвлөлөөс 2022 онд зохион байгуулсан 5 удаагийн тусгай шалгалтын тайланг Сонгон шалгаруулалтын газарт цахимаар тус тус хүргүүлэв.

Хоёр. Сул орон тооны сонгон шалгаруулалтын захиалгын талаар:

Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд 2022 оны дүнгээр салбар зөвлөлөөс төрийн захиргааны удирдах 2, гүйцэтгэх 13 албан тушаалын сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Сонгон шалгаруулалтын газарт албан бичгээр хүргүүлж, ажлын 10 хоног байгууллагын болон Төрийн албаны зөвлөлийн цахим сайтаар нийтэд зарлуулж байна.

Хүснэгт-1

№	Захиалга хүргүүлсэн албан бичгийн огноо, дугаар	Сул орон тоо		Албан тушаалын нэр
		Удирдах албан тушаал	Гүйцэтгэх албан тушаал	
1	2022.03.01 №01		3	Өмнөд бүс дэх газрын мэргэжилтэн-2; Баруун бүс дэх газрын мэргэжилтэн-1.
2	2022.04.06 №02		1	Санхүүгийн хэлтсийн хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн-1;
3	2022.04.19 №03		1	Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн мэргэжилтэн-1;
4	2022.06.02 №04		3	Виз, зөвшөөрлийн газрын виз зөвшөөрлийн мэргэжилтэн-1;

				Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн гадаад харилцааны мэргэжилтэн-1; Өмнөд бүс дэх газрын мэргэжилтэн-1.
5	2022.06.03 №06		1	Санхүүгийн хэлтсийн хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн-1;
6	2022.06.10 №07		2	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтсийн дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн-1; Өмнөд бүс дэх газрын мэргэжилтэн-1.
7	2022.10.26 №08		2	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтсийн ахлах мэргэжилтэн-1; Хойд бүс дэх газрын мэргэжилтэн-1.
8	2022.11.02 №09	2		Хөвсгөл аймаг дахь хэлтсийн дарга-1; Увс аймаг дахь хэлтсийн дарга-1.
ДҮН		2	13	

Гурав. Албан тушаалын тусгай шалгалт зохион байгуулсан талаар:

Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд 2022 онд салбар зөвлөлөөс төрийн захиргааны удирдах 4 (өмнөх онд зарласан 2 орон тоо), гүйцэтгэх 8 албан тушаалын сул орон тооны 5 удаагийн тусгай шалгалтыг зохион байгууллаа.

Тэнцсэн иргэдийн 2 буюу 16.6 хувь төрийн албанаас түр чөлөөлөгдсөн иргэдийн нөөцөд бүртгэлтэй, 5 буюу 41.6 хувь нь 2019-2021 оны төрийн албаны ерөнхий шалгалтын нөөцөд бүртгэлтэй иргэд, 5 буюу 41.6 хувь төрийн жинхэнэ албан хаагч эзэлж байна.

Хүснэгт-2

№	Тусгай шалгалт зохион байгуулсан огноо	Тоо		Тайлбар
		Удирдах албан тушаал	Гүйцэтгэх албан тушаал	
1	2022.01.28	2		Нөхсөн 2.
2	2022.04.06		3	Нөхсөн 3.
3	2022.05.13		1	Нөхсөн боловч тухайн иргэн өөр ажилд орсон тул дахин зарлуулсан.
4	2022.07.06		6	Нөхсөн 4, нөхөгдөөгүй 2 орон тоог дахин зарлуулсан.
5	2022.11.28	2	1	Нөхсөн 2, ахлах мэргэжилтний 1 орон тоо нөхөгдөөгүй.
ДҮН		4	11	

Тухайн албан тушаалын буюу тусгай шалгалтыг Төрийн албаны зөвлөлийн hh-admin.csc.gov.mn цахим системээр анх удаа зохион байгуулж, сонгон шалгаруулалтын захиалга, зар оруулах, бүртгэх, шалгалт авах, дүнг мэдээлэх бүх үйл явц цахимаар явагдаж, комиссын гишүүд, шалгуулагчид, иргэд мэдээллийг нээлттэй харах боломжтой болсон нь салбар зөвлөл, сонгон шалгаруулалтын комиссын үйл ажиллагаа, цаг хугацаа хэмнэсэн үр дүнтэй ажил боллоо.

Дөрөв. Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд:

Улсын Их Хурлаас 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр шинээр батлагдсан Төрийн хэмнэлтийн тухай хууль, Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр шинэчлэн баталж, энэ оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Кибер аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, холбогдох хуульд тусгайлан заасан зохицуулалтад нийцүүлэн зохион байгуулалтын

бүтцийн зарим нэгжийн орон тоо, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах зорилгоор тус агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцэд Засгийн газрын 2016 оны “Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Засгийн газрын агентлагийн орон тооны хязгаар”-т багтаан Гадаадын иргэн, харьяатын газрын зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тоонд өөрчлөлт оруулах саналын дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” А/177 дугаар тушаалаар байгууллагын төв, орон нутаг дахь бүтэц, орон тоог шинэчлэн батлуулж, байгууллагын даргын 08 дугаар сарын 30-ны өдрийн А/149, А/150 дугаар тушаалаар төв, орон нутаг дахь нэгжийн орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчиллээ.

Шинэчлэгдсэн бүтцийн хүрээнд дэд даргын албан тушаалын 1 орон тоог хасаж, зарим албан тушаалын чиг үүргийг тэнцвэржүүлэх зорилгоор Захиргаа, удирдлагын газрын өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтний 1 орон тоог Гадаадын иргэний бүртгэл, хяналтын цахим системд гадаадын иргэдийг бүртгэх, бүртгэлийг хянах, хасах үндсэн чиг үүрэгтэй ажилладаг онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага учраас шинэ орон тоо нэмэхгүйгээр “кибер аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтэн”-ий төрийн үйлчилгээний ангиллын орон тоонд шилжүүлэх, өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг Захиргаа, удирдлагын газрын нууц хариуцсан мэргэжилтний ажлын чиг үүрэгт шилжүүлсэн.

Орон нутаг дахь нэгжид батлагдсан орон тоонд багтаан “Хилийн боомт болон Монгол-Орос улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн дагуу Монгол-Оросын улсын хилийг нэвтрэх хилийн боомтуудын жагсаалтад багтсан олон улсын зорчигч, ачаа тээврийн харилцааны болон хоёр талын зорчигч, ачаа тээврийн харилцааны боомтод Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, Монгол Улсын Их Хурлын 2021 оны “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.3.1-т “агаарын замын байнгын ажиллагаатай олон улсын боомтын тоог нэмэгдүүлж, карго тээвэр, аялал жуулчлалыг хөгжүүлэх”, 1.4.2-т “зарим боомтыг түшиглэн хил орчмын аялал жуулчлалын хөгжүүлэх” эрх зүйн үндэслэл, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Баруун болон Хойд бүс дэх газарт 2 хэлтсийг шинээр байгууллаа.

Төрийн хэмнэлтийн тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль болон олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, шинэ сэргэлтийн бодлогын “боомтын сэргэлт”-ийн хүрээнд Гадаадын иргэн, харьяатын байгууллагын төлөөлөл ажиллах хилийн боомтуудын үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг дээшлүүлэх зорилгоор төрийн захиргааны удирдах 1 (шинээр байгуулсан Увс, Хөвсгөл аймаг дахь хэлтсийн дарга), гүйцэтгэх 1 (нууц хариуцсан мэргэжилтэн), нийт 2 албан тушаалын тодорхойлолтыг шинээр болон шинэчлэн боловсруулж, хянуулснаар Төрийн албаны зөвлөлийн 2022 оны “Зөвшөөрөл олгох тухай” 579 дүгээр

тогтоолоор, кибер аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтний төрийн үйлчилгээний ангиллын албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг шинээр боловсруулж, байгууллагын даргын 2022 оны А/151 дүгээр тушаалаар тус тус батлуулсан.

Дээрх албан тушаалын тодорхойлолтын дагуу шинээр байгуулсан 2 хэлтсийн даргын албан тушаалын сонгон шалгаруулалтыг 11 дүгээр сарын 28-ны өдөр салбар зөвлөлөөс зохион байгуулж, тухайн байгууллагад ажиллаж байгаа, ахлах түшмэлийн албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг бүрэн хангасан 2 төрийн жинхэнэ албан хаагчийг оролцуулан, шатлан дэвшүүлж томиллоо.

Төрийн албаны тухай хууль тогтоомж, байгууллагын “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны 2021-2024 оны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд байгууллагын даргын 03 дугаар сарын 28-ны өдрийн А/50 дугаар тушаалаар төв, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдын ажлын нэг өдрийн хоолны зардлын нөхөх төлбөрийг 15,000 төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

Шинэчлэн тогтоосон хоолны нөхөх төлбөрийг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож олгохыг Санхүүгийн хэлтэс, орон нутаг дахь нэгжийн дарга нарт зөвшөөрснөөр албан хаагчдад ажлын өдрөөр олгож байсан хоол, унааны зардал 8,500 төгрөг байсан бол өдрийн 15,500 төгрөг болгосноор нэг албан хаагчид сар бүр 176,000 төгрөгийн нөхөх төлбөр нэмэгдэж олгогдлоо.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/87 дугаар тушаалаар 5 албан хаагчид дэс түшмэлийн зэрэг дэвийг шинээр, 48 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан олгуулахаар шийдвэрлүүлсэн бөгөөд 07 дугаар сарын 01-ний өдрөөс зэрэг дэвийн нэмэгдлийг олгож эхэллээ. Мөн Зөрчил шалган шийдвэрлэх газрын болон Хойд бүс дэх газрын дарга нарт эрхэлсэн түшмэлийн “гутгаар зэрэг дэв”-ийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 162 дугаар захирамжаар ахиулан олгосныг 10 дугаар сарын 10-ны өдрөөс нэмэгдлийг олгож байна.

	Дэс түшмэл				Хүснэгт-3
	Тэргүүн зэрэг	Дэд зэрэг	Гутгаар зэрэг	Дөтгөөр зэрэг	Нийт
Шинээр	-	-	-	5	5
Ахиулан	7	25	16	-	48
НИЙТ					53

Төв, орон нутгийн нэгжүүдэд ажиллаж байгаа 214 төрийн захиргааны албан хаагчийн 141 буюу 65.8 хувь нь зэрэг дэвтэй мэргэшсэн албан хаагчид ажиллаж, сар бүр 18-36 хувийн нэмэгдэл олгож байна.

Зэрэг дэвтэй төрийн захиргааны албан хаагчдын 5 буюу 3.5 хувийг эрхэлсэн түшмэл, 58 буюу 41.1 хувийг ахлах түшмэл, 78 буюу 55.3 хувийг дэс түшмэл тус тус эзэлж байна.

Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын дагуу Б/51, Б/83, Б/109, Б/172, Б/243, Б/299 дүгээр тушаалаар нийт 39 албан хаагчид нэмэгдлийг, төвийн нэгжийн төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг улирлаар үнэлж, ур чадварын

нэмэгдлийг нийт 3 удаагийн тушаалаар давхардсан тоогоор 93 төрийн үйлчилгээний албан хаагчдад 10-25 хувийн нэмэгдлийг тус тус тооцож олгуулсан.

Мөн Засгийн газрын 2022 оны “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” 107 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны “Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 192 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг өөрчилсөнтэй холбогдуулан төв, орон нутаг дахь нэгжийн албан тушаалын цалингийн сүлжээний 1-4 дэх шатлалаар цалинждаг нийт 33 албан хаагчийн албан тушаалын цалинг Б/155 дугаар тушаалаар шинэчлэн тогтоолоо.

Хүснэгт-4

№	Төрөл	Хамрагдсан албан хаагч	Нэмэгдлийн хувь
1	Төрийн үйлчилгээний албан хаагчийн ур чадварын нэмэгдэл	93 /давхардсан тоо/	10-25
2	Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл	39	5-25
3	Илүү цагийн нэмэгдэл хөлс	13	-
4	Цалингийн шатлал ахиулсан	67	-
ДҮН		119	-

Тайлант хугацаанд хууль зүйн салбарын 34, төрийн дээд одон медалиар 13, байгууллагын жуух бичгээр 33, хөдөлмөрийн аварга 3, нэгжийн тэргүүнээр 12 нийт 95 албан хаагчийн мэдээллийг шагналын судалгаанд нэмж, баяжилт хийлээ.

Мөн 10 дугаар сараас 11 дүгээр сар хүртэлх хугацаанд шагналын судалгааг төв, орон нутаг дахь нэгжүүдэд хүргүүлж, ирүүлсэн судалгааг нэгтгэсэн. Энэ оны дүнгээр 45 албан хаагчид шагнал гардуулах ёслол хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулав.

Хүснэгт-5

№	Шагналын нэр	Шагнуулсан албан хаагчийн тоо
1	Цэргийн гавьяаны Улаан тугийн одон	1
2	Төрийн дээд шагнал Алтан гадас одон	2
3	Цэргийн гавьяаны одон	1
4	Төрийн дээд шагнал Хөдөлмөрийн хүндэт медаль	8
5	Цэргийн хүндэт медаль	1
6	Хууль зүйн албаны Тэргүүний ажилтан хүндэт тэмдэг	14
7	Хууль зүй, дотоод хэргийн яамны “Хүндэт жуух бичиг”	20
8	Гадаадын иргэн, харьяатын газрын “Жуух бичиг”	33
9	Байгууллагын Хөдөлмөрийн аварга, нэгжийн тэргүүн	15
ДҮН		95

Хөдөлмөрийн тухай хуулийн 68.1-д “ажил олгогч нь ажилтныг ажил үүргээ зайнаас цахим сүлжээгээр байнга, эсхүл хэсэгчлэн гүйцэтгэхийг зөвшөөрч, түүнтэй зайнаас ажиллуулахаар хөдөлмөрийн гэрээ байгуулж болно” гэж заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 1 албан хаагчийн зайнаас цахим сүлжээгээр буюу хэсэгчлэн ажиллах, байгууллагын даргын 2022 оны А/10 дугаар тушаалаар тусгай шалгалтад тэнцсэн тулгуур эрхтний бэрхшээлтэй 1 албан хаагчийн зайнаас буюу

хэсэгчлэн ажиллах цагийн хуваарийг тус тус батлуулж, албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах боломжийг бүрдүүлсэн.

“Жендэрийн эрхийг хангах орон тооны бус зөвлөл”-ийг 2022 оны А/64 дүгээр тушаалаар 6 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, зөвлөлийн ажиллах журмыг А/199 дүгээр тушаалаар батлуулав.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга энэ оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан түүнд нийцүүлэн байгууллагын даргын 05 дугаар сарын 03-ны өдрийн А/66 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-д ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, дарамт шахалтыг үл тэвчих орчныг бүрдүүлэх чиглэлээр 5 заалтыг тусгаж, үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын хэмжээнд хууль тогтоомж, хөдөлмөрийн дотоод журмын дагуу нийт 24 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсны 18 буюу 75 хувийг төрийн захиргааны албан хаагчид эзэлж байна. Сахилгын шийтгэлийг төрлөөр нь авч үзвэл: ажлаас халах 3 буюу 12.5, албан тушаалын цалинг бууруулах 8 буюу 33.3, нээлттэй буюу хаалттай сануулах 13 буюу 54.1 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт-6

№	Сахилгын шийтгэлийн төрөл	Төв		Орон нутаг	
		ТЗ	ТҮ	ТЗ	ТҮ
1	Өөрт нь хаалттай хэлбэрээр сануулах	-	-	2	1
2	Нийт ажилтанд нээлттэй хэлбэрээр сануулах	-	1	8	1
3	Албан тушаалын цалин бууруулах	3	2	2	-
4	Ажлаас халах	3	1	-	-
	ДҮН	6	4	12	2
		24			
	Сахилга, хариуцлагын талоныг цоолж сануулсан	3	-	13	4

Байгууллагын даргын тушаалд “сахилгын шийтгэл ногдуулсан тухай шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл энэхүү шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүхэд гомдол гаргах эрхтэйг дурдсан” заалтыг тусгаж хэвшсэн.

Мөн албан хаагчийн гаргасан зөрчил, дутагдалд дотоод хяналтын чиг үүрэг хариуцсан мэргэжилтнээс хийсэн хяналт шалгалтын дүнд удирдлагаас өгсөн үүрэг, чиглэл, Захиргааны ерөнхий хуульд заасныг тус тус баримтлан сонсох ажиллагаа зохион байгуулж, ажлын алдаа, зөрчил түүнийг шалгаж тогтоосон нөхцөл байдлыг тухай бүр танилцуулж хэвшсэн нь сахилгын шийтгэл ногдуулахтай холбоотой шийдвэрт гомдол, маргаан үүсэх эрсдэлийг бууруулдаг.

Тус байгууллагад төрийн албан хаагчийн сахилга, ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны хамтарсан 36/32 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам”-ын 2.2-т зааснаар Захиргаа, удирдлагын газрын дотоод хяналт хариуцсан албан хаагч журамд зааснаар шалгалт хийж, дүнг Ёс зүйн зөвлөл эсхүл байгууллагын Даргын дэргэдэх зөвлөлөөр оруулж, эрх бүхий албан тушаалтны

шийдвэрээр сахилгын болон ёс зүйн шийтгэлийг ногдуулж байна. Мөн Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа зохион байгуулж хэвшсэн.

“Хөдөлмөрийн дотоод журам”-ын дагуу ёс зүйн хариуцлагын талоныг 2017 оноос эхлэн ашиглаж эхэлсэн бөгөөд талоныг ажил үйлчилгээний стандарт, төрийн болон байгууллагын нууцын хадгалалт хамгаалалт, дүрэмт хувцас өмсөх, хэрэглэх журам зөрчсөн болон өгсөн үүрэг даалгавар хангалтгүй биелүүлсэн, бүрэн биелүүлээгүй, албаны сургалт олон нийтийн ажилд оролцоогүй гэсэн үндэслэлээр цоолж сануулга өгч хэвшсэн. Энэ оны дүнгээр төв болон орон нутгийн 20 албан хаагчийн “Ёс зүйн хариуцлагын талон”-д сануулах тэмдэглэгээ хийгдсэн бөгөөд 3 удаа тэмдэглэгээ хийлгэсэн тохиолдол сахилгын шийтгэл оногдуулах зохицуулалтыг хөдөлмөрийн дотоод журамд тусган мөрдөж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
САЛБАР ЗӨВЛӨЛ